



ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

**МОНГОЛ УЛС  
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА**

Жанжин Д.Сүхбаатарын талбай 7,  
1 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,  
Улаанбаатар хот, 15160 0035  
Утас: (976-11) 32 39 77, 32 71 99  
Цахим хуудас: www.ulaanbaatar.mn

2024.07.29 № 01/4320  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Тодруулга оруулах тухай**

Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зарласан НЗДТГ/20240101013 дугаартай “Эрчим хүч хуримтлуурын станцын ажил”-ын тендер шалгаруулалтад оролцогчоос тодруулга авах хүсэлт ирсэнтэй холбогдуулан дараах тодруулгыг хавсралтаар оруулж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэгт заасны дагуу тодруулгыг цахим системд нээлттэй байршуулснаар сонирхогч этгээдэд хүргүүлсэнд тооцно.

Хавсралт <sup>1</sup>... хуудастай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1110202144

Д/д	Оролцогчийн тодруулга	Хариулт
1	<p>ТШЗ 19.3-д дурьдсан тусгай зөвшөөрлүүд шаардна гэсэн байгаа ба Техникийн даалгавар Хүснэгт 8 “Гүйцэтгэгчийн авах зөвшөөрлүүд”-д тусгай зөвшөөрлийг Талбай дээр ажиллахаас өмнө авна гэж заасан байгаа.</p> <p>Иймд бид Техникийн даалгавар дээр байгаа заалтын дагуу тендерт шалгарсны дараа ТШЗ 19.3-д заасан 14 тусгай зөвшөөрлүүдийг талбайн ажил эхлэхээс өмнө бүрдүүлж шаардлагыг хангасан байна гэж ойлгож байна. Өөрөөр хэлбэл тендерийн материалдаа эдгээр 14 тусгай зөвшөөрлүүдийг хавсаргахгүй байж болно гэж ойлгож байна.</p>	<p>Төсөл хэрэгжүүлэх хугацаатай уялдуулан Захиалагчаас энэхүү тендерт оролцогч, түншлэл, туслан гүйцэтгэгч нь гүйцэтгэх үүргийнхээ дагуу тусгай зөвшөөрөлтэй байх шаардлага тавьсан бөгөөд тусгай зөвшөөрлийн талаарх мэдээллийг Тусгай зөвшөөрлийн цахим мэдээллийн сан (<a href="http://www.license.energy.gov.mn">www.license.energy.gov.mn</a>), Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>) -ээс шалгах тул тусгай зөвшөөрлийн хуулбарыг тендерийн материалд хавсарган ирүүлэх шаардлагагүй.</p>
2	<p>ТШЗ 19.3-д дурьдсан тусгай зөвшөөрөл дээр БХБЯ-ны БА-3.5-г шаардсан. Үүнийг Эрчим хүчний яамны ТЗ-2.4- тоот тусгай зөвшөөрлөөр дүйцүүлэн орж болох уу?</p>	<p>ТШЗ-ны 19.3-д “Эрчим хүчний эх үүсвэр, дулааны сүлжээ, түүний барилга байгууламжийн барилга угсралтын чиглэлээр бусад байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлүүдийг дүйцүүлэн тооцохгүй.” гэж туссан.</p>